

ШУУДАНГИЙН ХАРИЛЦАН ХОЛБОЛТЫН ЖУРАМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Шуудангийн үйлчлэгч нь сүлжээ хооронд, сүлжээ үйлчилгээ хооронд, үйлчилгээ хооронд нийтийн шуудангийн үйлчилгээг үзүүлэх харилцан холболт хийхдээ Монгол Улсын Харилцаа холбооны тухай хууль, Шуудангийн тухай хууль, Зөвшөөрлийн тухай хууль, Шуудангаар үйлчилгээ үзүүлэхэд мөрдөх дүрэм, шуудангийн стандарт эдгээрт нийцүүлэн гаргасан бусад дүрэм, журам болон энэхүү журмыг мөрдлөг болгоно.
- 1.2. Энэхүү журмын зорилго нь Монгол Улсад шуудангийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн шуудангийн сүлжээ, үйлчилгээний чанар, хүртээмж, мэдээллийн уялдааг нэмэгдүүлэх, харилцан холболтын хэрэгжилтийг хангуулахад оршино.
- 1.3. Энэхүү журмаар шуудангийн сүлжээ хооронд, сүлжээ үйлчилгээ хооронд, үйлчилгээ хооронд харилцан холболт хийх гэрээний нөхцөл тогтоох, харилцан холболтын төлбөр, орлого хуваарилах, зааглах цэг тогтоохтой холбоотой дараах төрлийн харилцааг зохицуулна. Үүнд:
 - 1.3.1. Харилцаа холбооны сүлжээ байгуулах, түүний ашиглалт үйлчилгээ эрхлэх /Шуудангийн сүлжээ байгуулах/ тусгай зөвшөөрөл эзэмшигч хооронд;
 - 1.3.2. Харилцаа холбооны сүлжээ байгуулах, түүний ашиглалт үйлчилгээ эрхлэх /Шуудангийн сүлжээ байгуулах/ тусгай зөвшөөрөл эзэмшигч, дотоодын болон улс хоорондын шуудангийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч хооронд;
 - 1.3.3. Дотоодын болон улс хоорондын шуудангийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч хооронд.

ХОЁР. ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- 2.1. Шуудангийн үйлчлэгч нь сүлжээ хооронд, сүлжээ үйлчилгээ хооронд, үйлчилгээ хооронд нийтийн шуудангийн үйлчилгээг үзүүлэх харилцан холболт хийхдээ Монгол Улсын Харилцаа холбооны тухай хууль, Шуудангийн

тухай хууль, Зөвшөөрлийн тухай хууль, Шуудангаар үйлчилгээ үзүүлэхэд мөрдөх дүрэм, шуудангийн стандарт эдгээрт нийцүүлэн гаргасан бусад дүрэм, журам болон энэхүү журмыг мөрдлөг болгоно.

- 2.2. Шуудангийн үйлчлэгч нь сүлжээ хооронд, сүлжээ үйлчилгээ хооронд, үйлчилгээ хооронд харилцан холболт хийх эрхтэй байна.
- 2.3. Шуудангийн үйлчлэгч нь харилцан холболт хийх гэрээний ерөнхий нөхцөлийг хангасан шуудангийн үйлчилгээ эрхлэгчийг өөрийн сүлжээ хооронд, сүлжээ, үйлчилгээ хооронд, үйлчилгээ хооронд харилцан холболт хийх боломжийг бүрдүүлнэ.
- 2.4. Шуудангийн үйлчлэгч нь сүлжээ хооронд (RIO), сүлжээ, үйлчилгээ хооронд (RAO) гэрээний нөхцөлийг боловсруулан Харилцаа холбооны зохицуулах хороо (Цаашид Зохицуулах хороо гэх)-гоор хянуулан баталж өөрийн веб хуудсанд байршуулах бөгөөд дараах мэдээллийг тусгасан байна. Үүнд:
 - 2.4.1. Тухайн сүлжээ хооронд, сүлжээ үйлчилгээ хооронд, үйлчилгээ хооронд харилцан холболт хийхэд мөрдөгдөх шуудангийн стандарт, нөхцөл шаардлага;
 - 2.4.2. Зааглах цэгийн байршил;
 - 2.4.3. Харилцан холболт хийх төлбөр, сүлжээнд холбогдох төлбөр тооцооны мэдээлэл;
 - 2.4.4. Гэрээ хийх үйл ажиллагааны нарийвчилсан мэдээлэл;
 - 2.4.5. Гэрээний загвар.
- 2.5. Шуудангийн үйлчлэгч нь сүлжээ хооронд, сүлжээ үйлчилгээ, үйлчилгээ хооронд харилцан холболт хийхдээ үйлчлүүлэгчийг ялгаварлахгүй үйлчлэх, ижил нөхцөлөөр хандах, ил тод байх
- 2.6. Үйлчилгээнд нөлөөлөх, эсвэл үйлчилгээг тасалдуулж болзошгүй саатал болон амралтын үеийн хуваарийг харилцан холбогдсон талуудад яаралтай мэдэгдэж шуурхай арга хэмжээ авна.
- 2.7. Харилцан холболтын явцад шинэ техник, технологи, шинэ бүтээгдэхүүн үйлчилгээг нэвтрүүлэхтэй холбоотой нэмэлт хөрөнгө оруулалт, зардлыг талууд харилцан тохиролцоно.

- 2.8. Шуудангийн үйлчилгээ эрхлэгч нь өөрийн системийн найдвартай байдлыг хангаж, гаднын халдлагаас хамгаалах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч ажиллах ба уг шаардлагыг хангаагүйн улмаас үүссэн хохирлыг хариуцна.
- 2.9. Шуудангийн үйлчлэгч нь энэхүү журам, холбогдох тусгай зөвшөөрлийн гэрээний дагуу сүлжээ хооронд, сүлжээ үйлчилгээ хооронд, үйлчилгээ хооронд харилцан холболтын талаарх шаардлагатай мэдээллийг тухай бүр Зохицуулах хороонд ирүүлж, тус хороог судалгаа хийх боломжоор хангана.

ГУРАВ. ХАРИЛЦАН ХОЛБОЛТ ХИЙХ ХҮСЭЛТ ГАРГАХ, ХҮЛЭЭН АВАХ, ХАРИУ ӨГӨХ

- 3.1. Шуудангийн үйлчлэгч нь харилцан холболт хийх хүсэлтийг шуудангийн үйлчилгээ эрхлэгчид бичгээр гаргана.
- 3.2. Шуудангийн үйлчлэгч нь уг хүсэлтийг хүлээн авч өөрийн сүлжээний техникийн боломж, гэрээний нөхцөлийг хангаж буй эсэхийг нягталж, өөр хоорондоо харилцан холболт хийх боломжтой эсэх талаар судалж, ажлын 10 хоногийн дотор хүсэлт гаргасан талд хариуг бичгээр мэдэгдэнэ.
- 3.3. Шуудангийн үйлчлэгч нь харилцан холболт хийх боломжгүй гэж үзсэн тохиолдолд уг шийдвэрийн үндэслэл, шалтгаан болон нөхцөлийг бүрдүүлэх боломжтой хугацааг тодорхой дурдсан тайлбарыг 3.2-т заасан хугацаанд багтаан хүсэлт гаргагчид хүргүүлж, хуулбарыг Зохицуулах хороонд ирүүлнэ.
- 3.4. Шуудангийн үйлчлэгч нь холбогдох технологийн болон бусад нөхцөлийг бүрдүүлж гэрээ байгуулна.

ДӨРӨВ. ТЕХНОЛОГИЙН НӨХЦӨЛ

- 4.1. Харилцан холболтын технологийн нөхцөл нь шуудангийн үйлчилгээний стандартын шаардлага хангасан байдал, шуудангийн илгээмжийг хүргэх хугацааны үзүүлэлтүүд байна.

- 4.2. Шуудангийн үйлчлэгч өөр хоорондоо харилцан холболт хийхдээ илгээмжийн бүртгэл, хяналт, хүргэлтийн төлөвийн мэдээллийг бодит хугацаанд системээр солилцох боломжийг бүрдүүлсэн байна.
- 4.3. Шуудангийн илгээмжийг хүлээн авах, ялган боловсруулах, хаягт эзэнд нь хүргэх үйл ажиллагаанд Шуудангийн аюулгүй байдал MNS 5539:2019, Шуудангийн үйлчилгээнд тавих шаардлага MNS 6776:2019 стандартыг мөрдөнө.
- 4.4. Талууд нь өөрийн үйлчилгээг өргөтгөх, шинэчлэх, татан буулгах зэрэг өөрчлөлтөөс үүдэн харилцан холболтод нөлөөлөхүйц нөхцөл байдал үүсэхээр бол мэдээллийг 3 сарын өмнө холбогдох талуудад болон Зохицуулах хороонд мэдэгдэнэ.

ТАВ. ЗААГЛАХ ЦЭГ ТОГТООХ НӨХЦӨЛ

- 5.1. Шуудангийн үйлчлэгч нь сүлжээ хоорондын харилцан холболтын зааглах цэг болон сүлжээ, үйлчилгээнд холбогдох зааглах цэгийн байршлыг тодорхойлж, сүлжээ хооронд (RIO), сүлжээ, үйлчилгээ хооронд (RAO) гэрээний нөхцөлд тусгана.
- 5.2. Зааглах цэг нь илгээмж солилцох байр талбай, тээврийн хэрэгсэл, шуудангийн ухаалаг хайрцаг, талуудын үйлчилгээний салбар цэг байна.
- 5.3. Шуудангийн үйлчлэгч нь зааглах цэгт илгээмжийн тоо, жин, дамжуулалтын мэдээллийг шуудангийн гардуулалтын дагавар болон бүртгэл хяналтын системээр баталгаажуулна.

ЗУРГАА. ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, АШИГЛАЛТ ҮЙЛЧИЛГЭЭ

- 6.1. Талууд зааглах цэгээс тус тусын ашиглалт үйлчилгээ, илгээмжийн бүрэн бүтэн, аюулгүй байдлыг хариуцна;
- 6.2. Харилцан холболтын үйлчилгээнд өөрийн үйлчилгээний чанарын үзүүлэлтээс бууруулахгүй байх;

ДОЛОО. ШУУДАНГИЙН ХАРИЛЦАН ХОЛБОЛТЫН ГЭРЭЭ

- 7.1. Талууд харилцан холболтын гэрээ байгуулахдаа дараах нөхцөлүүдийг тусгана.
 - 7.1.1. Шуудангийн илгээмжийг хүлээх авах, ялган боловсруулах, дамжуулах, хүргэлтэд мөрдөх, стандарт, хүргэлтийн графикт маршрутаар тооцон гаргасан илгээмжийг хүргэх хугацаа.
- 7.2. Талууд харилцан холболтын тарифыг Шуудангийн тухай хуулийн 18 дугаар зүйлд заасны дагуу үйлчлэгчийн эрх бүхий этгээдээр батлуулан мөрдөх ба харилцан холболт хийх үйлчилгээний тарифыг өртөгт үндэслэн талуудын эрх ашигт нийцүүлсэн байна.
- 7.3. Шуудангийн үйлчлэгч нь харилцан холболтын үйлчилгээний өртгийг тооцохдоо зайнаас хамаарсан, илгээмжийн төрөл, шуудангийн технологийн шат дамжлага, илгээмжийн ширхэг, жингийн шатлал, хүргэлтийн хугацааг харгалзан холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн хуулийн хүрээнд хөтөлсөн зардлын бүртгэлийг үндэслэнэ.
- 7.4. Шуудангийн харилцан холболтын төлбөр тооцоог солилцсон шуудангийн гадуур болон дотуур дагавар, бүртгэл хяналтын системийн мэдээлэлд үндэслэнэ.
- 7.5. Шуудангийн харилцан холболтын харилцаанд үүссэн орлогыг талууд харилцан ашигтай байхаар хуваарилах ба төлбөр тооцоог нийлэх хугацааг тохирно.
- 7.6. Шуудангийн үйлчилгээ эрхлэгчид өөр хоорондоо харилцан холболт хийх гэрээг энэхүү журмын дагуу зөвхөн бичгээр, монгол хэлээр байгуулна.
- 7.7. Шуудангийн үйлчилгээ эрхлэгчид өөр хоорондоо харилцан холболт хийх хүсэлтийг хүлээн авснаас хойш ажлын 10 хоногийн дотор гэрээ байгуулна.
- 7.8. Шуудангийн үйлчилгээ эрхлэгчид өөр хоорондоо харилцан холболт хийх гэрээнд талууд гарын үсэг зурсан өдрөөс хойш ажлын 10 хоногийн дотор уг гэрээ болон түүний хавсралт, холбогдох баримт бичгийн хамт Зохицуулах хороонд бүртгүүлэх ба уг гэрээнд орсон нэмэлт өөрчлөлт бүрийг тухай бүр бүртгүүлнэ.
- 7.9. Зохицуулах хороо нь энэхүү журмын дагуу байгуулаагүй харилцан холболт хийх гэрээг бүртгэхээс татгалзах эрхтэй бөгөөд шуудангийн үйлчилгээ эрхлэгч

нь уг гэрээг энэхүү журамд нийцүүлэн байгуулж, дахин бүртгүүлэхээр хандана.

- 7.10. Шуудангийн үйлчлэгч нь гэрээг байгуулахаас өмнө Зохицуулах хороонд хандаж, гэрээний төслийг хянуулах болон холбогдох заавар зөвлөмжийг авч болно.
- 7.11. Зохицуулах хороо бүртгүүлсэн гэрээний нэгдсэн санг бүрдүүлж ажиллах бөгөөд мэдээллийг олон нийтэд нээлттэй мэдээлнэ.

НАЙМ. МАРГААН ШИЙДВЭРЛЭХ

- 8.1. Энэхүү журам, гэрээг зөрчсөн болон харилцан холболттой холбоотой бусад маргаантай асуудлыг Харилцаа холбооны тухай хуулийн 9.1.12, 31.2-т заасны дагуу Харилцаа холбооны зохицуулах хороо бүрэн эрхийнхээ хүрээнд шийдвэрлэнэ.
- 8.2. Энэхүү журмын 7.8 дахь заалтын дагуу бүртгүүлээгүй гэрээтэй холбоотой үүссэн маргааныг Зохицуулах хороо шийдвэрлэхгүй.
- 8.3. Маргаантай асуудлыг шийдвэрлэхдээ Зохицуулах хороо дараах аргуудыг хэрэглэж болно. Үүнд:
 - 8.3.1. Маргаантай асуудлыг судлахын тулд шаардлагатай мэдээллийг талуудаас авч судлах, дүн шинжилгээ хийх, баримт гаргаж тавих;
 - 8.3.2. Талуудын тайлбар, саналыг сонсох, шаардлагатай гэж үзвэл олон нийтийн санал авах, хэмжилт, шалгалт хийх;
 - 8.3.3. Ижил төстэй байгууллагуудын болон олон улсын туршлагыг судлан харьцуулалт хийх, тухайн чиглэлээр мэргэшсэн мэргэжилтнүүдээс бүрдсэн ажлын хэсэг гарган ажиллуулах;
 - 8.3.4. Маргалдагч талуудын төлөөллөөс бүрдсэн ажлын хэсгийг санаачлан байгуулж, тухайн асуудлаар санал солилцуулан нэгдсэн шийдвэрт хүргэхэд чиглэсэн ажлыг зохион байгуулах;
- 8.4. Зохицуулах хороо нь маргаантай асуудлаар мэргэжлийн дүгнэлт гаргах, санал зөвлөмж өгөх, гэрээг дахин авч үзэх тухай хугацаатай үүрэг даалгавар

өгөх, маргааныг шийдвэрлэж болох хувилбаруудыг санал болгох зэргээр тодорхой шийдвэрийг гаргана.

- 8.5. Зохицуулах хороо нь маргаантай асуудлаар тухайн нөхцөл байдалд тохируулан үл ялгаварлах, шударга, өрсөлдөөнийг дэмжсэн шийдвэр гаргах ба шийдвэрийн талаар талуудад урьдчилан танилцуулж, саналыг нь авах, нээлттэй хуралдаанаар хэлэлцэж шийдвэрлэх замаар ил тод зарчмыг баримтална.
- 8.6. Маргалдагч талууд Зохицуулах хорооноос гаргасан шийдвэрийг хүлээж авахыг эрмэлзэх бөгөөд уг шийдвэрийг хүлээн зөвшөөрөхгүй бол шүүхэд хандаж болно.

ЕС. ХАРИУЦЛАГА ТООЦОХ

- 9.1. Энэхүү журмыг зөрчсөн тохиолдолд Зохицуулах хороо нь холбогдох хууль, тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

--- оОо ---